

Хуулийн сургаалтны үзэл , түүний онцлог

Ч.Таамаа - МУИС.ГХСС. Хятад судлалын тэнхмийн эрхлэгч, профессор

Түлхүүр үг : хуулийн шинэчлэл, хуулиар захирахуй, хууль, арга, хүч, нэр, цааз

Манай их хөрш Хятадад эрт үеэс философи сэтгэлгээ үүсч хөгжин, зургаан томоохон чиглэл гарч ирсэний нэг нь хуулийн сургаалтан мөн. Хуулийн сургаалтны философи нь байлдаант улсын үед буюу МЭӨ IY- III зууны үед үүсчээ. “Фа” гэсэн дүрс үсэг нь хууль, дүрэм гэсэн утгатай үг юм. Энэхүү хуулийн сургаалтны философийг өрнө дахинд легизм хэмээн нэрлэдэг. Чунь Цю улсын сүүл үеэр боолчуудын бослого тасралтгүй гарах болж, феодал газрын эздийн анги шинээр үүсэнээс үүдэн эрх баригч ангийн баримталж ирсэн “Ёсоор захирахуй” хэмээх тогтолцоо яваандаа суларч, хүч нөлөө үгүй болжээ.

Ингээд Күнзийн сургаалтны “Ёсоор захирахуй” хэмээх үзэл санааг шүүмжилж, мужийн эздийн улсад хуулийг өөрчлөн шинэчилж, хуулиар улсаа захирах эрмэлзэл бүхий шинэ философи болон хуулийн сургаал гарч иржээ. Байлдаант улсын эхэн үед Вэй улсын сайд Ли Куй (МЭӨ 455- МЭӨ 395он) “Хуулийн судар” зохиож , хамгийн түрүүнд Вэй улсын хуулийг засан шинэчилжээ. Түүний дараагаар Үү улсын хуулийг У Чи (МЭӨ 440- 381 он) засан шинэчлэв.

Байлдаант улсын дунд үед хуулийн сургаалтны эцэг хэмээн нэрлэгддэг Шан Ян (МЭӨ 390-МЭӨ 338 он) нь Чин улсын хуулийг засан шинэчлэв. Түүний үзлээр, улс орон тогтвортой хөгжих үндэс нь хүчтэй төр, сайн хууль байдаг. Хууль бол нийгмийн удирдлагын нэг чухал хэрэгсэл бөгөөд хууль нь өөртөө шагнал, шийтгэл гэсэн хоёр зүйлийг агуулдаг. Хуулийг дээдэлж, чанд сахин биелүүлсэн хүнийг шагнах, хууль зөрчсөн хүнд хатуу шийтгэл оноох нь зүйтэй хэмээн тэрээр хуулийн сургаалтны гол баримтлалыг анх боловсруулжээ. Энэ үзэл санааг дараа үеийн легистүүд уламжлан гүнзгийрүүлж хөгжүүлсэн билээ.

Шан Яны үзлээр, “Хууль нь ямар нэгэн нэр төр, албан тушаал харгалзахгүйгээр хүн бүрт адил хэмжээгээр үйлчилдэг байх ёстой. Хүн хэдий чинээ өндөр байр эзэлж байна, тийм хэмжээний өндөр хариуцлагыг хүлээх бөгөөд ямар нэгэн алдаа гаргавал тийм хэмжээний ял шийтгэл хүлээх хэрэгтэй. Тэгээд бас хуулийг онцгойлон авч үзэхийн зэрэгцээ төр засагт удирдах урлаг ихээхэн ач холбогдолтой гэж үзээд төрийг удирдагч хүн бол өргөн мэдлэгтэй, улс төрийн мэдрэмж сайтай байх хэрэгтэй. Төрийн гол зорилго бол ард түмний сайн сайхныг хангах ёстой.”²²

Цин Шихаун хуулийн сургаалтан Шан Яны үзэл баримтлалын дагуу төр засгийг тохинуулахад хууль гол үүрэгтэй хэмээн бүх хуулийг шинэчлэн боловсруулж, дагаж мөрдөж байсан нь үр дүнгээ өгч, түүний засаглалыг бэхжүүлж байжээ. Түүнчлэн хуулийн сургаалтны хариуцлага хүлээлгэх журмыг тэд сайтар хэрэгжүүлж байсан гэдэг. Тухайлбал, төрийн түшмэл хааны зарлиг зөрчих болон эрхэлсэн ажлаа дутуу дулимаг хийх юм бол

²² Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 125 дахь тал

хариуцлагыг тухайн түшмэл хүлээхийн зэрэгцээ бас тэр түшмэлийг төрийн албанд дэвшүүлсэн хэргэм тушаалтныг яллах ёстой байв.

Хуулийн сургаалтны өөр нэг гол төлөөлөгч Шэнь-Бухай гол анхаарлаа төрийн засаглалд хандуулсан буй. Тэрбээр төр гэдэг бол нуугдмал биш бүхий л хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байдаг засаглал юм. Хүчирхэг төр бол чиглүүлэн удирдах үйл явцад тодорхой бүх үйл ажиллагаа нь илэрхий явагддаг бөгөөд хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Удирдах урлагт тавих гол анхаарал нь хуулиас хамааран чиглэгдэнэ. Үүнийг хөгжүүлэхэд хуулиар хязгаарлагдаж бүх зүйлд хууль нээлттэй байж, төр засаг нь гартаа авч хэрэгжүүлж байх ёстой. Удирдах урлагийн гол зорилго бол хүнд суртлуудын мэдэлд ялгаж өгөх бус, тэдний авьяас чадлыг шалгаж амжилт бүтээлийг нь хянаж, хуулийг хөгжүүлэхэд оршино.

Шэнь-Дао “агуу их төр улс бол хуулин дээр үндэслэдэг гэж үзээд, хүнд сурталтан, хувиа хичээгч хүмүүст зориулж хууль үйлчилж болохгүй гэсэн чухал санааг дэвшүүлсэн буй. Хуулийн сургуулийг сонгодог утгаар хөгжүүлсэн Хань-Фэй-з нь Шэнь-Даогийн энэхүү үзэл баримтлалыг үргэлжлүүлжээ. Хань-Фэй-з цааш нь тэмдэглэхдээ засгийн хүрээнд хуулийг мөрдөж, дэг журмыг баримталж байх нь чухал. Эртний легизмын үзэл санааг нэгтгэн үзэхэд хууль дээр үндэслэсэн бүхэл бүтэн онолын чиглэлийг бий болгож, дээр нь удирдах урлагийн чиглэлийг төр өөртөө авч байх хэрэгтэй. Энэ онол нь ангиудын тогтвортой харилцаан дээр үндэслэн газар тариаланг улс төрийн нээлттэй бодлогын хэмжээнд явуулж, хөдөлмөрчин ард түмний агуу их хүчийг ашиглах түүний тусламжтайгаар өөрийнхөө хүчийг хамгаалах, мөн засаглалд ард түмний төлөө нээлттэй чанар байна гэдгийг онцолсон юм.

Хань улсын Шэнь Бү Хай, Жао улсын Шэнь Дао зэрэг хүмүүс дээрхи үзэл санааны дагуу тус тусын улсынхаа хуулийг засан шинэчлэх ажлыг гүйцэтгэж байсан байна. Тэдгээр хүмүүс тухайн үедээ өөр өөрийн улсдаа эрх мэдэл, хүч нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн байсан бөгөөд хараахан устгаж амжаагүй боолын эзэн язгууртан ангийн улс төр, эдийн засгийн ноёрхолыг бүрэн устгаж, феодалын улс төр, эдийн засгийн тогтолцоог байгуулж газрын эзэд шинээр хүчирхэгжин төрж байгаа эдийн засгаа хөгжүүлэхийн төлөө “хуулийн шинэчлэл” – ээр дамжуулан хуучин язгууртнуудын улс төрийн давуу ноёрхолыг устгах, хуучин улс төрийн тогтолцоог шинэ язгууртнуудын улс төрийн тогтолцоогоор шинэчлэн солих, төрийн эрхийг феодалын эздийн гарт төвлөрүүлэхийг идэвхитэй санаачлан уриалж байв.

Энэ суурин дээр тэд хуулийг олон нийтэд хүртээмжтэйгээр боловсруулан тунхаглаж, улс даяар хүн бүрийн үзэл санааг нэгтгэхээр улам их уриалсаар байв. Улс орныг “Төрийн хуулиар захирах” явдлыг идэвхитэй санаачилж зүтгэлтэй хэрэгжүүлж байсан тэдгээр улс төрийн зүтгэлтнүүдийн үзэл санааны онол болон хэрэгжилт нь олон янзын үзэл санааны урсгалын ширүүн тэмцэл дунд явагдаж байжээ. Ялангуяа Хавар Намар байлдаант улсын үед маш их хүчтэй нөлөөлсөн юм.

Тэд ард түмнийг “Хуулиар захирахуй”-г гол зорилгоо болгож байсан учраас тэднийг “хуулийн сургаалтан” гэж нэрлэсэн юм. Хуулийн сургаалтны гол төлөөлөгчид гэвэл өмнө дурдсан Ли Куй, У Чи, Шан Ян, Шэнь Бү Хай, Шэнь Дао нараас гадна тэднээс бүр өмнө байсан Гуань Жун, Зи Чань нарыг ч дурдаж болно. Гэхдээ хуулийн сургаал нь бүхэл бүтэн нэг үзэл санааны урсгал болон өргөжихөд хамгийн их үүрэг гүйцэтгэсэн хүн бол хожим гарч ирсэн Хань Фэй-з билээ.

Хань Фэй (МЭӨ 280- 233 он) нь язгууртан удмын гэр бүлд төрсөн гайхалтай сэтгэгч байсан тул Хань Фэй-з хэмээн өргөмжлөгдсөн буй. Тэрээр байлдаант улсын сүүл үе буюу Хань улсын үед амьдарч байсан бөгөөд Сүнзийн шавь байсан гэдэг. Хань Фэйн философийн үзэл санаанд Сүнз болон урьд үеийн хуулийн сургаалтны үзэл санаа ихэд нөлөөлсөн учир тэрээр Хань улсын Ванд хуулиа засан шинэчлэхийг олон удаа санал болгож байсан боловч огтхонч хүлээн зөвшөөрсөнгүй. Тиймээс өөрийн өмнөх үеийн хуулийн сургаалтны онол үзэл санааг эмхэтгэн цэгцэлж, "Хань Фэй-з" хэмээх 55 бүлэг зохиолсо туурвижээ. Түүний философийн үндсэн баримтлал нь "Тэнгэрийн доорхийг захирахдаа хүний уг чанарын дагуу үйлдэх хэрэгтэй. Хүний уг чанарт хайрлах, жигших сэтгэл зуршмал байдаг тул шагнал, шийтгэл хүчтэй. Шагнал, шийтгэл хоёр үр ашигтай бол тушаал, тогтоол гаргаж болох ба удирдах зам өөрөө тогтоно."²³ бөгөөд түүний үзлээр, "Хуулийн өмнө бүх хүн бүгд тэгш эрхтэй. Төрийн эзэн хууль ба нэр сүрээрээ хүмүүсийг захирна".

Хожим нь түүний туурвисан бүтээлийг Цин Ши Хуан хаан соёрхон үзээд, санаанд нь их нийцсэн тул Хань Фэйг Цин улсад дуудан авчруулсан байдаг. Эцэст нь Цин улсын дотоод зөрчлийн улмаас тэрээр Чин улсын сайд Ли Си-д хорлогдсон хэмээн үздэг. Гэвч Цин Ши Хуан хаан Хань Фэйгийн сургаалыг ашиглаж хятад улсыг нэгтгэх их үйлсээ биелүүлсэн түүхтэй. Тэр бүхнийг Хань фэйгийн сургаал болон бүхий л хуулийн сургаалтны үзэл санааны агуу их амжилт ялалт юм гэж хэлж болно.

Хань Фэйгийн сургаал бол юун түрүүнд Сүнзийн үзэл санаанд тулгуурласан бөгөөд Лаозийн үзэл санаанд шингээстэй юм бүхэн өөртөө эсрэг тэсрэгийг агуулдаг учир харьцангуй өөрчлөгдөж байдаг, хувь заяа бурхан тэнгэр байдаг гэдгийг үгүйсгэж, зөвхөн хүний хүч чадал, юмс үзэгдлийн бодит зүй тогтлын дагуу аливаа үйлийг хийхийг эрхэмлэдэг үзэл болно.

Түүний үзлээр, "Нийгмийн түүх ч байнга хувьсан өөрчлөгддөг. Түүхэн эрин үе бүр өөрийн онцлогтой. Эрт үед хүн ам цөөн, эд баялаг ихтэй, дао болох сайн үйлийг дагаж мөрдөж байв. Дундад зууны үед оюун ухаан ба заль мэх хоёр тэмцэлдэх болжээ. Орчин үед хүн ам олон, эд баялаг хомс, эрх мэдлийн төлөө тэмцэл хүчтэй болсон байна". Ийнхүү түүхэн үе бүрт өөр өөрийн асуудал байдаг бөгөөд түүнийг шийдэх арга зам ч олон буй гэдгийг тэрээр авч үзжээ. Хань Фэй улс орны мандан мөхөхийн учир шалтгаан нь зөвхөн түүний хүчирхэгт үү, сул дорой юу гэдэгтэй огт хамаагүй зүйл юм гэж үздэг байжээ. Тэрээр энэ талаар Жао улс Янь улсыг буулгаж авахаар довтолж байсан тухай тодорхой жишээ татан өгүүлсэн байдаг. Тухайн үед Жао улс дайнд ялалт байгуулах ерөөл тавилантай гэж мэргэ төлөгт бууж байсан боловч харин ч эсрэгээр ялагдал хүлээсэн байна.

Энэ бүхэн бурхан тэнгэр байдаг гэдэг нь оргүй хоосон зүйл, бурхан тэнгэр хэмээн мухраар сүсэглэх нь доройтож мөхөхийн шинж тэмдэг гэдгийг харуулж байна. Хань Фэйгийн үзлээр, аливаа юмс үзэгдэл нь өөр өөрийн хөгжлийн зүй тогтолтой бөгөөд бодит зүйлийг л танин мэдэж болно. Иймд хүмүүс юмс үзэгдлийн хөгжлийн хандлагыг чиг шугамаа болгож, юмс үзэгдлийн зүй тогтолын дагуу ажил үйлсээ хийх нь зүйтэй гэж үзэж байв. Үүний тулд тэрээр аливаа зүйлийн үр дүнг нь эрхэмлэдэг байжээ.

Хань фэй танин мэдсэн аливаа зүйлийн үнэн худлыг шалгахдаа үйл явдалын бодит үр дүнг шалгуур болгох хэрэгтэй. Хэрэв төлөвлөж байсан үр дүндээ хүрээгүй бол хэдий сайн ярьж, хэдий сайн зүтгээд ч ямар ч нэмэр болохгүй гэж сургадаг байв. Иймээс бодит байдлыг эрхэмлэж, хоосон ярихыг

²³ Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006. 54 дэх тал

тэвчих нь Хань фэй - н сургаал, бас бүхий л хуулийн сургаалтны үзэл санааны өвөрмөц онцлогуудын нэг юм.

Хань фэйгийн сургаалын гол агуулга бол Шэнь Бү Хай, Шэнь Дао, Шан Ян зэрэг түрүү үеийн хуулийн сургаалтнуудын үзэл санааг нэгтгэсний үндсэн дээр “хуулиар захирахуй” –г гол түлхүүр болгож, хууль, арга, хүч гурвыг нэгтгэн хослуулахыг эрхэмлэж байв. Шэнь Бү Хай бол зөвхөн аргыг л ярьдаг, харин хуулийг чухалчилдаггүй, Шан Ян бол зөвхөн хуулийг чухалчлаад аргыг ярьдаггүй. Эдгээр нь дан дангаараа эзний ноёрхолд ямар ч ашиг тусгүй. Хамгийн зөв арга бол хууль, арга, хүч гурвыг нэгтгэн хослуулах хэрэгтэй гэж тэр үзэж байлаа. Ийнхүү Хань Фэй өөрөөсөө өмнөх үеийн хуулийн сургаалтнуудын үзэл баримтлалын өрөөсгөл байдлыг даван туулж, тэдгээрийг нэгтгэн шинэчилсэн философич юм.

Хань Фэй юун түрүүнд засгийн эрхийг нэгэн тэнгэрийн доор нэгтгэж чадах хэм хэмжээ бол “Хууль” гэдэг санааг дэвшүүлжээ. Тэрээр “хууль”-ийг бүх нийтээр заавал хүндэтгэн сахиж, “хууль” –ийг зөрчсөн хэнийг ч бай яллан шийтгэж байх хэрэгтэй гэж уриалж байсан байна. Тэрчлэн хуулийг “нэр” хэмээн, хуулийн дагуу ял шийтгэл оноохыг “Цааз” хэмээн нэрлэсэн ажээ. Энэ бол түүний алдарт “хууль цаазын арга” юм.

Тэрээр мөн төрийн эрхийг сахин хамгаалахад “хууль”-иас гадна “арга” хэрэгтэй хэмээн үзэж байв. “Арга” гэдэг нь төрийн эзэн хүний “хууль” –ийн дагуу эрх мэдлээ хэрэгжүүлэх хэрэгсэл юм. “Хууль”, “Арга” зэргээс гадна Хань Фэй “Хүч”-ийг мөн чухалчилдаг байв. “Хүч” гэдэг нь засгийн эрх юм. “Хүчтэй болно” гэдэг нь засгийн эрхийг атгана гэсэн үг аж. Хань Фэй “хүч” гэдгийг “Байгалиас заяасан хүч” хэмээн ангилаад, “хүний буй болгосон хүч”-ийг илүүтэй чухалчилан үзэх хэрэгтэй гэдгийг онцолжээ. Өөрөөр хэлбэл, засгийн эрхийг атгаж, түүнийгээ улам бэхжүүлэхийн тулд “хүч” ба “хууль” –ийг хослуулах хэрэгтэй ажээ.

Түүний дэвшүүлсэн бас нэгэн гол санаа бол төрийн эрх мэдэл бүхий феодалын эзэрхийлэн захирах засгийн эрхийн шаардлагад нийцэхийн тулд хүмүүсийн үзэл санааг нэгтгэх хэрэгтэй гэжээ. Энэ үед зөвхөн хуулийн сургаалыг тахин шүтэж, бусад сургаалыг хориглох нь зүйтэй гэж сургаж байв. Цин Шихуан хаан Хань Фэйгийн үзэл санаанд үндэслэн Хятад улсыг нэгтгэснийхээ дараа хуулийн сургаалтны бодлогыг албадан хэрэгжүүлж, Күнзийн сургаалтан зэрэг бусад урсгалын сэхээтэн хүмүүсийг хэлмэгдүүлж байжээ. Энэ талаар зарим жишээ хэлэхэд, Күнзийн ном зохиолыг шатааж, 460 күнзийн сурталтныг амьдаар нь булж амь насыг нь бүрэлгэсэн байдаг.

Ерөнхийдөө Хань Фэйгийн сургаал бол түрүү Чин улсын хуулийн сургаалтны үзэл санааны ноёрхолыг хамгийн өндөр оргилд нь хүргэж чадсан юм. Хэдийгээр хуулийн сургаалтны үзэл санаа Цин Шихуан хааныг Хятадын түүхэн дэх хамгийн анхны төвлөрсөн эрхт феодал гүрнийг байгуулахад нь тус дөхөм үзүүлж чадсан боловч Цин улсын төр тийм ч удаан оршин тогтноогүй юм. Цин Ши Хуан хаан болон Чин Ар Ши хаан нар дан ганц хуулийн сургаалтны бодлогыг баримталж, маш харгис хатуу хууль цааз хэрэгжүүлж, бусад сургаалыг хүчээр хорьж, ард түмнийг хэрцгийгээр дарлаж байсан зэрэг нь Цин улсын төр маш хурдан сүйрч мөхөх шалтгаан болсон юм.

Хань улс байгуулагдсаны дараа буюу Хань Ү ди хааны үед Чин улсын бодлогоос эсрэгээр “Бусад сургаалыг халж, зөвхөн Күнзийн сургаалыг шүтэх” гэсэн шинэ төрийн бодлого хэрэгжүүлснээр Күнзийн сургаалтны үзэл санаа бат бэх сууриа олж, хуулийн сургаалтны урсгал устан үгүй болжээ. Хожим нь Хятад улсад хуулийн сургаалтны урсгал дахин шинээр гарч ирээгүй юм. Хэдийгээр хуулийн сургаалтны нөлөө багассан ч түүний үзэл санаа огт устаж мөхөөгүй юм. Энэ урсгалын үзэл санаа феодалын ноёрхолын засгийн эрхийг

бэхжүүлэхэд хэрэглэсээр хэвээр байсан бөгөөд үе үеийн феодалын ноёрхогч ангиудад залгамжлагдан үлдсээр байв.

Түүнчлэн Күнзийн сургаалтны үзэл санаатай хослуулан хэрэглэж байсан нь Хятадын феодалын нийгмийн чухал хэрэгсэл болж байв. Хуулийн сургаалтны үзэл санаа бол үндсэндээ улс төр- эрх зүйн философи юм. Хэдийгээр түүний үндсэн агуулга аль эрт үеийн боловч одоо ч нийгэм-улс төрийн амьдралд тодорхой хэмжээнд ач тусаа өгсөн хэвээр байдаг байна.

Дүгнэлт

Өмнө өгүүлснээс үзвэл, улс оронд эмх цэгц, дэг журмыг тогтооход сайн хууль, чанд сахилга бат, мөн шагнал, шийтгэлийг зөв хэрэглэх нь хамгийн чухал гэдгийг хуулийн сургаалтны үзэлд гол баримтлал болгодог онцлогтой байна. Гэвч хүний болон нийгмийн харилцааг дан ганц хуулиар зохицуулна гэсэн баримтлал нь нэг талыг барьсан өрөөсгөл үзэл юм. Нийгмийн харилцааг зохицуулахад хуулиас гадна ёс суртахууны зохицуулалт бас чухал үүрэгтэй байдгийг хуулийн сургаалтнууд үл ойшоосонд тэдний үзэл баримтлалын нэг сул тал оршиж байна.

Ашигласан ном зохиол

- F.Дарьхүү. Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006
- Liu ze hua . Zhong guo chuan tong zheng zhi si xiang fan si, sheng huo . Du shu . Xi zhi chu ban she , 1987
- Ren xu yu . Zhong guo zhe xue shi. Ren min chu ban she. 1964
- Ben shu bian xie zu . Wen shi da quan he bei jiao yu chu ban she. 1991
- Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. Орч. Ү.Нямдорж. УБ., 2003